



СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН ЯАМ

**ТӨЛӨВЛӨГӨӨТ БУС
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТЭМДЭГЛЭЛ**

2026 он

	АГУУЛГА	
НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ	2
1.1 Шалгалт хийх үндэслэл:	2
1.2 Санхүүгийн хяналт шалгалтын зорилго:	2
1.3 Санхүүгийн хяналт шалгалтын хамрах хүрээ, хязгаарлалт	2
ХОЁР. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ҮР ДҮН	2
ГУРАВ: ИЛЭРСЭН АСУУДАЛ	6
ДӨРӨВ: ДҮГНЭЛТ	7
ТАВ: ЦААШИД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ САНАЛ	7

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Шалгалт хийх үндэслэл: Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.3 дахь хэсэг, Засгийн газрын 2015 оны “Дүрэм батлах тухай” 483 дугаар тогтоолын хавсралтаар баталсан Дотоод аудитын дүрмийн 5 дугаар зүйлийн 5.1.3 дахь заалтын хүрээнд Авлигатай тэмцэх газрын 2026 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 05/1165 дугаар албан бичгээр ирүүлсэн иргэний гомдолд дурдсан 8 асуудалтай холбоотой Засгийн газрын тохируулагч агентлаг Биеийн тамир, спортын улсын хорооны 2024, 2025 оны холбогдох зардлын гүйцэтгэлд санхүүгийн хяналт шалгалтыг хэрэгжүүллээ.

1.2 Санхүүгийн хяналт шалгалтын зорилго: “Монголын тэшүүрийн холбоо”-нд тамирчдыг тэмцээн уралдаанд явуулахад дэмжлэг үзүүлсэн төсвөөс олгосон санхүүжилтийн зардлын гүйцэтгэлтэй холбоотой иргэний гаргасан аргадалд дурдсан асуудлаар санхүүгийн хяналт шалгалт гүйцэтгэн, шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгуулах, цаашид авах арга хэмжээний дүгнэлт, санал гаргахад оршино.

1.3 Санхүүгийн хяналт шалгалтын хамрах хүрээ, хязгаарлалт

Хамрах хүрээ: Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Биеийн тамир, спортын улсын хорооноос 2024, 2025 онд “Монголын тэшүүрийн нэгдсэн холбоо”-нд олгосон санхүүжилтийн зардалтай холбоотой гомдолд дурдсан 8 асуудалд санхүүгийн хяналт шалгалтыг гүйцэтгэнэ.

Хязгаарлалт: Дээрх асуудлаас бусад үйл ажиллагааг хязгаарласан болно.

Санхүүгийн хяналт шалгалт хийсэн хугацаа: 2026 оны 02 дугаар сарын 04-ний өдрөөс 03 дугаар сарын 09-ний өдрийг дуусталх хугацаанд санхүүгийн хяналт шалгалтыг гүйцэтгэнэ.

ХОЁР. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ҮР ДҮН

1. “Биеийн тамир, спортын улсын хорооны даргын 2024 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн А/187 дугаар тушаалаар Үндэсний шигшээ багийн тамирчдын тэмцээн болон бэлтгэл хийх хамгаалалтын хэрэгсэл, материалын зардал баталсан. Хамгаалалтын хэрэгсэл, материал авч өгөөгүй.” гэсэн асуудлыг шалгахад:

Монголын Тэшүүрийн холбоо нь Олон улсын Тэшүүрийн холбооны Communication No 2365-д заасан шорт трекийн тамирчдын бэлтгэл сургуулилт болон уралдаан тэмцээн зохион байгуулахад зайлшгүй шаардагддаг “Тоноглогдсон хамгаалалтын зөөлөвч”-ийг БНХАУ-аас 64,000 ам долларын үнээр худалдан авч, Шанхай хотоос тээвэрлэн авчрах **тээврийн зардал** 45,800 юань буюу 23,779.4 мянган төгрөгийн дэмжлэг хүсэж шийдвэрлүүлэхээр 2024 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн 27 дугаар албан бичгийг Биеийн тамир, спортын улсын хороонд хүргүүлсэн байна.

Тус албан бичгийн дагуу Биеийн тамир, спортын улсын хорооны даргын 2024 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн А/187 дугаар тушаалаар 23,779.4 мянган төгрөгийн зардал баталж, холбооны дансанд 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр 23,779.4 мянган төгрөгийг шилжүүлсэн байна.

Уг тушаалаар гарсан зардал нь тээвэрлэлттэй холбоотой зардал байхад тушаалын агуулга хэсэгт “...тамирчдын тэмцээн болон бэлтгэл хийх хамгаалалтын хэрэгсэл материал авах зардал” гэж утга найруулгын алдаатай гаргасан байна.

Хамгаалалтын зөөлөвчийг тээвэрлэхэд гарсан зардлын гүйцэтгэлийг анхан шатны баримттай тулган шалгахад зөрчил илрээгүй болно.

2. *“Биеийн тамир, спортын улсын хорооны даргын 2024 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн А/357 дугаар тушаалаар Гэгээ өргөө” цогцолборт бэлтгэлд гаргахаар 15,000.0 мянган төгрөг баталсан. Тус байранд бэлтгэл гараагүй.” гэсэн асуудлыг шалгахад:*

Биеийн тамир, спортын улсын хорооны даргын 2024 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн А/357 дугаар тушаалаар Тэшүүрийн Үндэсний шигшээ багийн тамирчдыг зуны бэлтгэл цугларалтад зориулж 15,000.0 мянган төгрөгийн зардал баталж, холбооны дансанд 2024 оны 06 дугаар сарын 11-ний өдөр 15,000.0 мянган төгрөгийг шилжүүлсэн байна. Гүйцэтгэлийн анхан шатны баримттай тулган шалгахад Монголын Тэшүүрийн холбоо нь Тэрэлж дэх “Гэгээн өргөө” цогцолборт тамирчдыг бэлтгэлд сургуулилтад гаргахаар Бүрэг трэйд ХХК-ай хамтран ажиллах гэрээ байгуулж, гэрээ дүгнэсэн акт үйлдсэн байна.

Тус байранд тамирчид байрлаж бэлтгэл сургуулилалт хийж байгааг нотлох баримтжуулсан фото зураг, тайлан санхүүгийн баримтад байхгүй, тухайн газар байрласан эсэх нь бүрэн нотлогдохгүй байна.

Энэ талаар Тэшүүрийн холбооноос нотлох баримтыг шаардсан боловч Хөвсгөл аймагт тэмцээнтэй явж байна гэсэн тайлбартайгаар хяналт шалгалтын хугацаанд баримт ирүүлээгүй болно.

3. *“Бүгд найрамдах Солонгос улсад 2024 оны 07 дугаар сарын 15-ны өдрөөс 08 дугаар сарын 20-ны өдрийн хугацаанд хамтарсан бэлтгэлд гарсан. Өсвөрийн тамирчдын бүх зардлыг гэр бүлээс нь Үндэсний тэшүүрийн холбоо авсан боловч бүгд нэг өрөөнд, өөрсдөө хоолоо хийж идсэн.” гэсэн асуудлыг шалгахад:*

Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1. *Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна.* Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 5.1.3. *“төсвийн хөрөнгөөр хийгдэж байгаа үйл ажиллагаа болон төсвийн санхүүжилт, зарцуулалт, түүний үр ашигтай байдал”* хяналт шалгалтыг хэрэгжүүлнэ гэж заасны дагуу Дотоод аудитын газар нь зөвхөн төсвөөс авсан санхүүгийн дэмжлэгийн зарцуулалтад хяналт тавих чиг үүрэгтэй.

Тус асуудалтай холбоотой өсвөрийн тамирчдын бүх зардлыг гэр бүлээс нь Тэшүүрийн холбоо авсан гэх асуудалд санхүүгийн хяналт шалгалт хийх боломжгүй болно.

4. *“Дэлхийн цомын цуврал 4 тэмцээнд оролцох Үндэсний шигшээ багийн тамирчдын зардлыг 5 хүнээр баталсан боловч 3 хүний бүрэлдэхүүнтэй оролцсон.” гэсэн асуудлыг шалгахад:*

Тус тэмцээн нь хэзээ хаана, хэдний өдөр зохион байгуулагдсан эсэх нь тодорхойгүй байгаа учраас хяналт шалгалт хийх боломжгүй байна. Биеийн тамир, спортын улсын хорооноос Тэшүүрийн Үндэсний шигшээ баг дэлхийн цомын цуврал 4 тэмцээнд оролцсон эсэх холбоотой тушаалыг шүүлгэхэд Биеийн тамир, спортын улсын хорооны даргын 2024 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн “Тэшүүрийн Үндэсний шигшээ багийн тамирчид дэлхийн цомын аварга шалгаруулах тэмцээнд оролцох зардал гаргах тухай” А/663 дугаар тушаалыг ирүүлсэн боловч уг асуудалтай холбоотой тушаал мөн эсэх нь тодорхой бус байна.

/Авлигатай тэмцэх газраас гомдол гаргасан хүний нэрийг нууцалсан учраас асуудлыг тодруулах боломжгүй байна./

5. “Биеийн тамир, спортын улсын хорооны даргын 2024 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн А/72 дугаар тушаалаар гадагшаа тэмцээнд явсан. Нэг тамирчны виз гараагүй. Зардлыг яаж зарцуулсныг мэдэхгүй.” гэсэн асуудлыг шалгахад:

Биеийн тамир, спортын улсын хорооны даргын 2024 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн “Тэшүүрийн үндэсний шигшээ багийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээн, дэлхийн цомын аварга шалгаруулах тэмцээний зардал батлах тухай” А/72 дугаар тушаалаар Польш улсын Гданьск хотноо 02 дугаар сарын 16-18, 22-25-ны өдрүүдэд дэлхийн цомын аварга шалгаруулах тэмцээн, залуучуудын дэлхийн аварга шалгаруулах тэмцээн, Голланд улсын Роттердам хотноо 03 дугаар сарын 15-17-ны өдрүүдэд дэлхийн аварга шалгаруулах тэмцээнүүдэд 4 хүний бүрэлдэхүүнтэй оролцуулахаар нийт 74,303.8 мянган төгрөгийн зардал баталж, холбооны дансанд 2024 оны 02 дугаар сарын 09-ний өдөр 74,303.8 мянган төгрөгийг шилжүүлсэн байна.

Тус тушаалаар баталсан 4 тамирчны нэг М.Борхүүгийн виз гаргаагүй улмаас тус тэмцээнд оролцоогүй, 3 хүний бүрэлдэхүүнтэй тэмцээнд явсан байна.

Тэшүүрийн холбооноос бүрэлдэхүүн дутуу явсан шалтгаанаар 10,760.3 мянган төгрөгийн зардлын буцаалтыг Биеийн тамир, спортын улсын хорооны дансанд шилжүүлсэн байна. Уг тэмцээнд олгосон нийт зардлын нэг хүнд ногдох зардлын дүнг аудитаар тооцож үзэхэд 16,070.3 мянган төгрөг бөгөөд Монголын Тэшүүрийн холбооноос буцаасан дүнг хасахад 5,310.1 мянган төгрөг илүү зарцуулсан байна. Үүнийг тодруулбал онгоцны тийз 1,486.4 мянган төгрөг, мөсний төлбөр 2,304.7 мянган төгрөг, машин түрээс, шатахуун, замын төлбөр 4,898.9 мянган төгрөгөөр илүү зарцуулж, байр, хоолны зардлыг 3,379.9 мянган төгрөгөөр хэмнэсэн байна.

А/72 тушаалын баталсан зардлын гүйцэтгэл

Хүснэгт:1/мянган төгрөгөөр/

Зориулалт	Баталсан	Гүйцэтгэл	Аудитаар 3 хүнд ногдох зардал	Зөрүү(илүү дутуу)
Замын зардал онгоц	9,917.2	8,924.3	7,437.9	+1,486.4
Байрны зардал	31,218.6	21,707.1	23,413.9	- 1,706.8
Хоолны зардал	19,631.3	13,050.2	14,723.4	- 1,673.1
Мөсний төлбөр	2,635.6	4,061.8	1,757.0	+2,304.7
Машин түрээс шатахуун, замын төлбөр	10,900.9	15,799.9	10,900.9	+4,898.9
Нийт	74,303.6	63,543.3	58,233.1	+5,310.1
Буцаалт		10,760.3		

Байр, машин түрээсийн зардалд зарцуулсан нийт 37,507.0 мянган төгрөгийн гүйцэтгэл анхан шатны баримтаар бүрэн нотлогдохгүй байна. Тухайлбал Дэлхийн аль ч газраас байр түрээсийн үйлчилгээ үзүүлдэг **Airbnb** онлайн платформуор дамжуулан 9 удаагийн захиалгын хуудас, машин түрээсийн нэхэмжлэл зэргийг санхүүгийн баримтад хавсаргасан байна. Захиалгын хуудас, нэхэмжлэлийн дагуу төлбөр тооцоо хийсэн төлбөрийн баримт байхгүй байна. Мөн тухайн захиалсан байранд байрласан эсэхийг нотлох зураг тайлан, төлбөр баталгаажсан баримт байхгүй байна.

6. “Биеийн тамир, спортын улсын хорооны даргын 2024 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн А/720 дугаар тушаалаар Үндэсний шигшээ багийн тамирчин биш байхад төсөв баталсан. Тээтэл Дэлхийн цомын эрх хийх тэмцээнд явах шигшээ багийн тамирчдад зардал батлаагүй хувийн зардлаар явсан.” гэсэн асуудлыг шалгахад:

Биеийн тамир, спортын улсын хорооны даргын 2024 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн “Дэлхийн оюутны өвлийн универсиад наадам оролцоход зардал гаргах тухай” А/720 дугаар тушаалаар уран гулгалтын ганцаарчилсан төрөлд тамирчин, дасгалжуулагч гэсэн 2 хүний бүрэлдэхүүнтэй оролцуулахаар нийт 33,032.2 мянган төгрөгийг баталж, холбооны дансанд 2024 оны 12 сарын 24-ны өдөр 33,032.2 мянган төгрөгийг шилжүүлсэн байна. Гүйцэтгэлийг санхүүгийн анхан шатны баримттай тулган шалгахад зөрчил илрээгүй болно.

Мөн үндэсний шигшээ багийн тамирчдын зардлын ангиллаас тус зардлыг гараагүй, олон улсын тэмцээн, уралдааны зардлын ангиллаас санхүүжилт гарсан байна.

Үндэсний шигшээ багийн тамирчин биш байхад төсөв баталсан гэх асуудал нь “Дэлхийн оюутны өвлийн универсиад наадамд оролцох баг, бүрэлдэхүүнд дэмжлэг үзүүлэх гэрээ”-г Биеийн тамир, спортын улсын хороо Монголын Тэшүүрийн холбоотой байгуулж, сүүлийн 2 жилийн хугацаанд Япон улсад бэлтгэл сургуулилалт хийж байгаа өвлийн наадмын топ төрөл болох уран гулгалтын ганцаарчилсан төрөлд тамирчныг оролцуулахаар дэмжлэг үзүүлсэн байна.

Албан бичигт дурдсан “Дэлхийн цомын эрх хийх тэмцээнд явах шигшээ багийн тамирчдад зардал батлаагүй хувийн зардлаар явсан” гэх асуудал нь хэзээ хаана зохион байгуулагдсан тэмцээнд шигшээ багийн хэдэн хүн явсан эсэх нь тодорхой бус байгаа учраас санхүүгийн хяналт шалгалт хийх боломжгүй байна. /Авлигатай тэмцэх газраас гомдол гаргасан хүний нэрийг нууцалсан учраас асуудлыг тодруулах боломжгүй байна./

7. “Бүгд Найрамдах Солонгос улсад дотоодын цугларалтад 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдрөөс 06 дугаар сарын 23-ны өдрүүдэд гарах зардал баталсан. Тус баталсан зардлын байр, хоолны мөнгө зөрүүтэй.” гэсэн асуудлыг шалгахад:

А/138 тушаалын баталсан зардлын гүйцэтгэл

Хүснэгт:2 /мянган төгрөгөөр/

Зардлын нэр	Хүний тоо	Хоног	Нэгж үнэ	Нийт баталсан зардал	Гүйцэтгэл	Зөрүү буюу буцаасан дүн
Дотоод сэргэлтийн зардал	5		120.0	600.0	600.0	
Замын зардал	5	-	1,431.2	7,156.3	7,071.1	-
Байр			5,421.3	19,369.9	21,239.1	-
Хоол	5	38	45.0 вон	21,460.5	19,689.8	-
Бэлтгэлийн заал түрээс			6,560ам доллар	23,438.4	23,438.4	-
Нийт дүн				72,025.1	72,038.4	-

Биеийн тамир, спортын улсын хорооны даргын 2025 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн “Тэшүүрийн Үндэсний шигшээ багийн дотоодын бэлтгэл, хамтарсан бэлтгэлд оролцох зардал батлах тухай” А/138 дугаар тушаалаар Бүгд Найрамдах Солонгос улсад дотоодын цугларалтад 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдрөөс 06 дугаар сарын 23-ны өдрүүдэд бэлтгэлд гарахад 72,025.1 мянган төгрөгийн зардал баталсан байна.

Гүйцэтгэлийг анхан шатны баримт, ажлын тайлантай тулган шалгахад байрны зардлаас бусад зардал нь санхүүгийн анхан шатны баримттай зөрчил илрээгүй.

Харин байрны зардалд зарцуулсан 21,239.1 мянган төгрөгийн гүйцэтгэл анхан шатны баримтаар бүрэн нотлогдохгүй байна. Тухайлбал Дэлхийн аль ч газраас байр түрээсийн үйлчилгээ үзүүлдэг **Airbnb** онлайн платформоор дамжуулан 2024 оны 06 дугаар сарын 03-ны өдөр 3 удаагийн захиалгаар нийт 5944.4 ам доллар буюу 21,239.1 мянган төгрөгийн захиалга хийж, санхүүгийн баримтад захиалгын хуудас хавсаргасан байна. Захиалгын хуудасны дагуу төлбөр тооцоо хийсэн төлбөрийн баримт байхгүй байна. Мөн захиалгын хуудсыг тэмцээн эхлэх хугацаанаас зөрүүтэй хойш захиалсан, мөн тухайн захиалсан байранд байрласан эсэхийг нотлох зураг тайлан, төлбөр баталгаажсан баримт байхгүй байна.

8. “Биеийн тамир, улсын хорооны даргын 2024 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн А/557 дугаар тушаалаар Филиппин улсын Манила хотод зохион байгуулагдсан тэмцээний төсвийг баталсан. Тэмцээний үеэр бэлэн мөнгө 10000 песо өгсөн. Өдрийн 50 доллар зарцуулаагүй. Баталсан төсөв зөрүүтэй.” гэсэн асуудлыг шалгахад:

Биеийн тамир, спортын улсын хорооны даргын 2025 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн “Тэшүүрийн Үндэсний шигшээ багийн тамирчид дэлхийн цомын эрхийн тэмцээнд зардал гаргах тухай” А/557 дугаар тушаалаар 5 хүний бүрэлдэхүүнтэй оролцуулахаар нийт 29,372.3 мянган төгрөгийн зардал баталж, холбооны дансанд 2024 оны 09 дүгээр сарын 23-ны өдөр 29,372.3 мянган төгрөгийг шилжүүлсэн байна.

Гүйцэтгэлийг анхан шатны баримттай тулган шалгахад Филлипин улсын Тэшүүрийн холбооноос тамирчдын хураамжийг 6 хүнээр , байр, хоолыг 7 хүнээр тооцож нийт 5930 ам доллар болно гэсэн нэхэмжлэл Монголын Тэшүүрийн холбоонд ирүүлснийг гүйцэтгэлийн баримтад хавсаргасан байна.

Энэхүү нэхэмжлэлийн дагуу төлбөр тооцоо хийсэн төлбөрийн баримт байхгүй байгаа нь тамирчдын хураамж, байр хоолны нийт 15,855.6 мянган төгрөг төлсөн нь нотлогдохгүй байна. Мөн тухайн газар байрласныг нотлох тайлан мэдээ, фото зураг байхгүй байна.

ГУРАВ: ИЛЭРСЭН АСУУДАЛ

1. Биеийн тамир, спортын улсын хорооны даргын 2024 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн А/187 дугаар тушаалын агуулга хэсэгт тээвэрлэлтийн зардал бус Тэшүүрийн Үндэсний шигшээ багийн тамирчдын тэмцээн болон бэлтгэл хийх хамгаалалтын хэрэглэл материал авахаар бэлтгэл хангах зардал гэж утга найруулгын алдаатай гаргасан байгаа нь Захиргааны ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.5 “Зорилгодоо нийцсэн, бодит нөхцөлд тохирсон, шийдвэр нь үндэслэл бүхий байх” заалтад нийцээгүй байна. (Асуудал 1)
2. Тэшүүрийн холбоо нь Бүрэг трейд ХХК-тай тэрэлж дэх “Гэгээн өргөө цогцолбор”-т бэлтгэл цугларалтад гаргах 15,000.0 мянган төгрөгийн Хамтран ажиллах гэрээ байгуулж, гэрээг дүгнэсэн боловч тухайн объектод байрласныг нотлох тайлан мэдээ анхан шатны баримт байхгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3.1.3. “анхан шатны баримт” гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэл, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог”, Төсвийн тухай хуулийн 6.4-д заасан төсвийг үр ашигтай, хэмнэлттэй зарцуулах зарчимтай нийцэхгүй байна. (Асуудал 2)
3. Биеийн тамир, спортын улсын хорооны даргын 2024 оны А/72, А/557, 2025 оны А/138, дугаар тушаалаар баталсан зардлын байр, хоол, машины түрээс нийт 74,601.7 мянган төгрөгийн гүйцэтгэл анхан шатны баримтаар бүрэн нотлогдохгүй

байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3.1.3."анхан шатны баримт" гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоо", Төсвийн тухай хуулийн 6.4-д заасан төсвийг үр ашигтай, хэмнэлттэй зарцуулах зарчимтай нийцэхгүй байна. (Асуудал 5,7,8)

ДӨРӨВ: ДҮГНЭЛТ

Авлигатай тэмцэх газрын 2026 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 05/1165 дугаар албан бичгээр ирүүлсэн иргэний гомдолд дурдсан 8 асуудалд хяналт шалгалтыг хэрэгжүүлэхэд Биеийн тамир, спортын улсын хорооны даргын 2024 оны А/72, А/357, А/357, 2025 оны А/138 дугаар тушаалаар нийт 190,701.0 мянган төгрөгийн зардал баталснаас санхүүгийн анхан шатны баримтаар бүрэн нотлогдохгүй **89,601.7** мянган төгрөг буюу баталсан зардлын 46.9 хувьд асуудал илэрлээ. Иймд Санхүүгийн хяналт шалгалтын Улсын ахлах байцаагчийн албан шаардлага хүргүүлж, Төсвийн тухай хуулийн 5.1.5 "Хариуцлагатай байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл Нягтлан бодох бүртгэлийн зарчим 5.1.4 "Үнэн зөв байх" зарчмыг мөрдөж ажиллахыг даалгаж, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгч ажиллалаа.

ТАВ: ЦААШИД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ САНАЛ

Хяналт шалгалтын дүнгээр илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, гүйцэтгэлийн санхүүгийн анхан шатны баримтыг холбогдох байгууллагаас бүрэн гаргуулж авч, дотоод хяналтыг сайжруулан ажиллахыг Биеийн тамир, спортын улсын хорооны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Билэгтэд даалгаж, Санхүүгийн хяналт шалгалтын Улсын ахлах байцаагчийн албан шаардлагаар хугацаатай үүрэг даалгавар, 2 зөвлөмж хүргүүлж байна. Үүнд:

Зөвлөмж 1. Зардал баталж буй тушаал шийдвэрийг төлөвлөн гаргахдаа холбогдох хууль, дүрэм журмын хүрээнд боловсруулан зарцуулж буй төсөл арга хэмжээний утгыг зөв гаргаж байх;

Зөвлөмж 2. Төсвийн зарцуулалтын гүйцэтгэлийг гаргахдаа холбогдох байгууллагаас санхүүгийн анхан шатны баримтыг бүрэн авах, зардлыг илүү, дутуу дүнгээр зарцуулсан эхэсийг хянаж байх.

Хяналт шалгалтын дүгнэлтэд үндэслэн өгсөн зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээ авч хэрэгжүүлэн биелэлтийг 2026 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор яамны Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт ирүүлэх.

СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН ЯАМ